



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

199⁹ Яны 9-р сарын 9 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг суралцуулах тухай

ТУШААХ НЬ:

1. Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах 1998 оны уралдаант шалгалтад тэнцсэн Дундговь аймгийн Мал эмнэлгийн газрын дарга, малын их эмч **Содномын Батсайханыг** Англи Улсын Рийдин хотын их сургуулийн магистрантурт мал эмнэлгийн халдварт өвчин судлалын мэргэжлээр, ТИС-ийн багш **Ядамсүрэнгийн Энхтуяаг** Их Британы Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Манчестрийн их сургуулийн ЮМИСТИЙН шинжлэх ухаан, технологийн институтийн магистрантурт буудайн биохимиийн судалгааны чиглэлээр **ХААУЯ-ны** нэр дээр тус бүр нэг жилийн хугацаагаар, УИХ-ын Тамгын газрын техникийн хэлтсийн программист **Батсүхийн Саранчимэгийг** АНУ-ын Гавайн Номхон далайн их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн мэргэжлээр 1999 оны хуваарьт багтаан УИХ-ын Тамгын газрын нэр дээр 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу **С.Батсайхан, Я.Энхтуяа, Б.Саранчимэг** нартай гэрээ байгуулан холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / С.Алтангэрэл / -д тус тус даалгасугай.



ГЭГЭРЛИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

А.БАТТӨР